



ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

Эмч томилолтоор ажиллуулах, сургалт зохион байгуулах тухай


Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, МУ-ын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний 3.3.11, Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаал, Төвийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.6.3, 2.6.4, 2.6.5 дахь заалт, 3 дугаар зүйлийн 3.2.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ЭМС-ын 2025 оны “Эхийн ноцтой хүндрэл, эхийн болон перинатал эндэгдлийг магадлан хэлэлцэх, хариу арга хэмжээ авах журам” А/419 дугаар тушаал, “Эх, хүүхдийн өвчлөл, эндэгдэлтэй холбоотой нэр томъёоны тодорхойлолт”, “Эхийн ноцтой хүндрэл, эхийн эндэгдэл, амьгүй төрөлт, эмнэлгийн болон эмнэлгийн бус нөхцөлд эндсэн тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, төрөлхийн хөгжлийн гажгийг мэдээлэх тандалтын журам”, “Эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийн тандалтын мэдээллийн урсгал” А/420 дугаар тушаалууд, Монгол Улсын Засгийн газрын “Алсын хараа-2050”, “Тогтвортой хөгжлийн зорилт-2030”, ДЭМБ-ын “Эхийн болон перинатал эндэгдлийн тандалт, хариу арга хэмжээ”-ний удирдамжийн хэрэгжилтийг хангах зорилгын хүрээнд “Эхийн болон перинатал эндэгдлийн тандалт, хариу арга хэмжээ” сургалтыг зохион байгуулах зорилгоор 2026 оны 03 сарын 08-16-ны өдрүүдэд мэргэшлийн эмч нарын багийг Архангай, Завхан аймгуудад томилолтоор ажиллуулсугай.

2. Хөдөө орон нутагт томилолтоор ажиллах багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, томилолтоор ажиллах сургалтын удирдамж, хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Томилолтоор ажилласан эмч нарын томилолтын зардлыг тооцон олгохыг Санхүү, бүртгэлийн албаны ахлах нягтлан бодогч /М.Жавхлан/-д зөвшөөрсүгэй. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн албаны дарга /Б.Мөнхшүр/-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Ж.ОТГОНБААТАР

1606660015